



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/8/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас:7058-4203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас:7058-4204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас:7058-4207 Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, АРГА зүй, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	5
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө.....	7
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	8
2.8.3 Авлага.....	8
2.8.4 Урьдчилгаа.....	8
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт.....	8
2.8.6 Бараа материал	9
2.8.7 Үндсэн хөрөнгө	9
2.8.8 Өр төлбөр.....	9
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо	10
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
2.11. Шилэн дансны мэдээлэл	12
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	12
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	13
3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	14
3.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
3.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	21
4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22



Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ДОА	Дорнод аймаг



Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1. Аудитын гэрчилгээ


ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
21000, Дорнод аймаг, Хөрсгэн сум 7-р баг
ЗДТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

ЦАГААН-ОВОО СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.БАЯРМАГНАЙ ТАНАА

Аудит № 03.25 № 322
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цагаан-Овоо сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цагаан-Овоо сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагаан-Овоо сумын төсвийн гүйцэтгэлийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520262



Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Т.Баярмагнай танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цагаан-Овоо сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 15-наас 2020 оны 03 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Д.Нармандах гүйцэтгэв.

Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 02-ний өдрийн 1/132 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Цагаан-Овоо сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журамд өөрчлөлт гараагүй байна.

Цагаан-Овоо сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, аудитын алба нь 2019 онд Цагаан-Овоо сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр зөвлөмж өгөөгүй байна.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Цагаан-Овоо сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 16 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 16 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг зардлын 1 хувь буюу 34.9 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 төрийн /орон нутгийн/ өмчит аж ахуйн нэгж, 2 тусгай сан, нийт 9



Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 8 байгууллага аудитад хамрагдсан, Ерөнхий боловсролын сургуульд итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 5 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгч, 3 байгууллагын тайланг түүвэрт хамруулан шалгаж, илэрсэн асуудлыг нэгтгэсэн тайланд тусгалаа

- Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 9.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс *Сум хөгжүүлэх сангийн* зээлийн хүүгийн 8.3 сая төгрөгийн авлагыг бүртгэл тайланд тусгаагүй байсныг аудитын явцад залруулж, 1.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн үзүүлэлт байхгүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

ИТХ нь худалдан авалтын 1,374.2 мянган төгрөгийн анхан шатны Е баримтыг хавсаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.5 дахь хэсэгт “... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлээ.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 12.1 сая төгрөгийн залруулга хийлээ. Үүнд:

- *Цагаан-Овоо сумын Засаг даргын тамгын газар*: Биет бус хөрөнгө /газар/-нд 2.5 сая төгрөгийн элэгдлийг тооцож зардлаар бүртгэснийг санхүүгийн тайланд залруулсан.
- *Эрүүл мэндийн төв*: Зардал хооронд 155.0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан, ЭМГ, БОЭТ зэргээс хуваарилагдан ирсэн төсөл хөтөлбөрөөс үнэ төлбөргүй ирсэн 4 төрлийн 9,5 сая төгрөгийн эмийг орлого, зарлагаар бүртгэлийг хийлгэсэн.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7



Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

~~тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 150.1 сая, эцсийн үлдэгдэл 85.7 сая төгрөг болж, 64.4 сая төгрөгөөр буурсан байна.~~

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<u>Касст байгаа бэлэн мөнгө</u>				
<u>Банканд байгаа бэлэн мөнгө</u>	150.1	85.7	-64.4	
<u>Замд яваа мөнгөн хөрөнгө</u>				
<u>Дүн</u>	150.1	85.7	-64.4	

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 83.7 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 2.0 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд бичилт хийгдээгүй байна.

2.8.3 Авлага

Авлага ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансны эхний үлдэгдэл 197.9 сая, эцсийн үлдэгдэл 396.9 сая төгрөг болж, 199.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад авлага	-	152.6	+152.6
Зээлийн авлага	198.5	252.5	+54.1
<u>Дүн</u>	198.5	405.1	206.6

Авлагын үлдэгдэлд Сум хөгжүүлэх сангийн 1-4 жилийн насжилттай зээл, зээлийн хүүгийн 157.4 сая төгрөгийн он дамжсан авлага байгааг шилжүүлсэн байна.

Энэ нь төсөвлөсөн арга хэмжээ хүрэх үр дүндээ хүрэхгүй байх, сангаас аж ахуй нэгж, иргэнд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихэд үзүүлэх зээл олголтын эх үүсвэр дутагдах зэрэг сөрөг үр дагавартай байна.

Аудитын илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хүүгийн 8,3 сая төгрөгийн авлагыг бүртгээгүй байна.

2.8.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансанд гүйлгээ хийгдээгүй байна.



Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.8.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 335.7 сая, эцсийн үлдэгдэл 366.0 сая төгрөг болж, 30.3 сая төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	150.4	166.3	+15.9
Эм боох материал	-	1.3	+1.3
Бичиг хэргийн материал	45.9	49.3	+3.4
Аж ахуйн материал	14,6	15,3	+0,7
Түлш, шатах тослох материал	2,7	3,7	+1,0
Хүнсний материал	0	0,1	+0,1
Бусад хангамжийн материал	7.0	6.2	-0.8
Мал амьтад	115.1	123.8	+8.7
Дүн	335.7	366.0	30.3

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай аж ахуйн материалыг худалдан авсан, мал амьтдын нас дэвшилтэй холбоотой байна.

Мөн ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа материал байхгүй байна.

Аудитын илрүүлэлт: Сумын ИТХ нь худалдан авалтын 1,374.2 мянган төгрөгийн анхан шатны Е баримтыг хавсаргаагүй байна.

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 5,344.9 сая, эцсийн үлдэгдэл 5,674.1 сая төгрөг болж, 329.2 сая төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	3,393.0	3,540.9	147.9
Авто тээврийн хэрэгсэл	105.2	199.8	94.6
Машин тоног төхөөрөмж	496.0	461.0	-35.0
Тавилга эд хогшил	112.8	135.1	22.3
Зам гүүр байгууламж	20.9	24.6	3.7
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	651.2	651.2	-
Бусад үндсэн хөрөнгө	356.5	452.1	95.6
Биет бус хөрөнгө	209.3	209.1	0.1
Дүн	5,344.9	5,674.1	329.2

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл~~

ДОА-2020/8/СТА-ТТЗ



Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

0.2 сая эцсийн үлдэгдэл 75.2 сая төгрөг болж, 75.0 сая төгрөгөөр өссөн байна.

<u>Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл</u>				<u>/сая төгрөг/</u>
<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өссөн+ Буурсан -</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Байгууллагад төлөх өглөг	0.2	74.7	74.5	99.3
Хувь хүмүүст төлөх өглөг	-	0.5	0.5	0.7
<u>Нийт дүн</u>	0.2	75.2	75.0	100

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл өссөн ОНХС-гаар хийгдсэн хөрөнгийн санхүүжилт дутуу олгогдсоноос шалтгаалсан байна.

Урт хугацаат өр төлбөрийн дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

Аудитын илрүүлэлт: Аймгийн ОНХС-гаас 147.5 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосноос 74.7 сая төгрөгийн өглөг үүссэн байна.

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,028.8 сая эцсийн үлдэгдэл 6,455,7 сая төгрөг болж, 426.9 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалттай холбоотой байна.

Хүснэгт № 31 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт/+, бууралт -/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
<u>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</u>	3,949.4	3,949.4	-	61.2
<u>Хуримтлагдсан үр дүн</u>	-335.5	91,3	+426.9	1.3
<u>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</u>	2,414.9	2,414.9	-	37.5
<u>Бодлогын өөрчлөлт алдааны залруулга</u>	-	-	-	-
<u>Дүн</u>	6,028.8	6,455.7	+426.9	100.0

Засгийн газрын оруулсан капитал данс өөрчлөлт ороогүй байна

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд өөрчлөлт ороогүй байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Formatted: Font: Arial, Font color: Auto, Mongolian (Cyrillic)

Formatted: Centered, Space After: 0 pt

Formatted: Font: (Default) Arial, Bold, Mongolian (Cyrillic)



Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Цагаан-Овоо сумын ИТХ-ын “2019 оны орон нутгийн төсөв батлах” тухай 03 дугаар тогтоолд сумын төсвийн орлогын төлөвлөгөөг 77.4 сая төгрөгөөр баталсан нь гүйцэтгэлээр 106.5 сая төгрөгийн буюу 137.6 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	2.0	5.4	3.4	270.0
Шууд бус орлого	22.0	37.7	15.7	171.4
Бууны албан татвар	2.8	1.5	-1.3	53.6
Улсын тэмлэгтийн хураамж	3.1	2.0	-1.1	64.5
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	25.0	21.6	-3.4	86.4
Бусад татвар	2.5	15.0	12.5	600.0
Хадгаламжийн хүүгийн орлого	17.0	21.8	4.8	128.2
Торгуулийн орлого	3.0	1.5	-1.5	50.0
Нийт дүн	77.4	106.5	29.1	137.6

Орлогын төлөвлөгөө 29.1 сая төгрөгөөр давсан нь хадлангийн орлого, хадгаламжийн хүүгийн орлого давж биелсэнтэй холбоотой байна.

Хүү торгуулийн, Улсын тэмдэгтийн хураамж, бууны албан татварын орлогыг өмнөх оны гүйцэтгэлээр төлөвлөсөн нь тасарсан байна. Энэ нь ... шалтгаалсан байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,562.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,236.0 сая төгрөгийг урсгал зардалд, 326.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2,477.0 сая төгрөгийг улс, орон нутгийн төсвөөс, 35,9 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 50,0 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,425.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 954.9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, эрүүл мэндийн даатгалын сангаас 0.6 сая төгрөгийн санхүүжилтийг авсан нь гүйцэтгэлээр олгогдсонтой холбоотой байна. Мөн аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 145.5 сая төгрөгийг санхүүжилтийг олгоогүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,371.0 сая төгрөг буюу 92,5 хувьтай зарцуулсан нь орон нутгийн хөгжүүлэх сангийн санхүүжилт дутуу ирснээс хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүйтэй, орон тоо дутуу ажилласан, зардлын хэмнэлтийн гүйцэтгэлтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 22 төсөл, арга хэмжээнд 326,9 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 186,8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 150.9 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3.1 мянга, нийт 154.0 мянган төгрөгийн нэмэлт төсвийг бүрдүүлжээ.

Үүнээс: Үлийн цагаан оготно устгах зардалд 21.4 сая төгрөг, Хангамж, бараа материалын зардалд 51.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 60.6 сая төгрөг, гамшгийн зардалд 21.0 сая төгрөг, нийт 154.0 сая төгрөгийг бүрэн зарцуулсан байна.



2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

1. Сумдын засаг дарга нар нь Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-д хамаарахгүй, урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулахаар захирамж гаргаж байгааг анхаарах шаардлагатай байна.

2.Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 147,4 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Цагаан-Овоо сумын төсвийн төвлөрүүлэн захирагч Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 139 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг биелэлтийг 2019 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн 1/220 дугаар албан бичгээр гарган ирүүлсэн байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Цагаан-Овоо сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	684 259 559,36	856 850 093,08
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	150 086 748,49	85 701 722,76
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	150 086 748,49	85 701 722,76
3121	Төгрөг	150 086 748,49	85 701 722,76
31211	Төрийн сангийн харилцах	146216613,70	83750064,17
31213	Арилжааны банк дахь харилцах	3870134,79	1951658,59
33	АВЛАГА	198 481 313,00	405 157 099,25
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	597 929,00	9 445,25
335	Бусад авлага	197 883 384,00	405 147 654,00
3351	Байгууллагаас авах авлага		152604700,00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	197883384,00	252542954,00
35	БАРАА МАТЕРИАЛ	335 691 497,87	365 991 271,07
351	Түүхий эд материал	150 417 084,92	167 600 624,92
35110	Тусгай зориулалттай материал	150417084,92	166301744,92
35130	Эм боох материал	-	1 298 880,00
354	Хангамжийн материал	70 184 412,95	74 595 646,15
35410	Бичиг хэргийн материал	45876356,95	49257894,15
35420	Аж ахуйн материал	14549950,00	15343563,00
35440	Түлш, шатах тослох материал	2726200,00	3679543,00
35460	Хүнсний материал		124500,00
35470	Бусад хангамжийн материал	7031906,00	6190146,00
35600	Мал амьтад	11509000,00	123795000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5 344 819 153,23	5 674 090 878,64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5 344 819 153,23	5 674 090 878,64
392	Биет хөрөнгө	5 135 537 753,63	5 464 711 223,78
39201	Барилга, байгууламж, орон сууц	3676340860,67	3944819904,67
39202	Хуримтлагдсан элэгдэл	-283326395,92	-403933429,02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	272755584,00	356255584,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-167599467,03	-156505108,59
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	775826560,29	851861698,29
39206	Хуримтлагдсан элэгдэл	-279825149,85	-390863259,79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	237274110,67	285590419,57
39208	Хуримтлагдсан элэгдэл	-124564138,57	-150468018,84
39209	Зам, гүүрийн байгууламж	100646692,00	105646692,00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-79702469,14	-80981922,82
39213	Түүх соёл, музейн дургалт зүйлс	651170000,00	651170000,00
39214	Бусад үндсэн хөрөнгө	650816933,98	834948933,98
39215	Хуримтлагдсан элэгдэл	-294275367,47	-382830269,67
393	Биет бус хөрөнгө	209 281 399,60	209 379 654,86
39301	Програм хангамж	7867140,00	8799340,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3975740,40	-4809685,14
39303	Бусад биет бус хөрөнгө	205 390 000,00	205 390 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6 029 078 712,59	6 530 940 971,72



Цагаан-Овоо сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	232 840,00	75 212 400,00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	232 840,00	75 212 400,00
413	Өглөг	232 840,00	75 212 400,00
4136	Бусад өглөг	232 840,00	75 212 400,00
41361	Байгууллагад төлөх өглөг	181879,00	74702400,00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	50961,00	510000,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6 028 845 872,59	6 455 728 571,72
51	Засгийн газрын хувь оролцоо	6 028 845 872,59	6 455 728 571,72
